ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дадал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2025/055/НА-СТА-ТШЗ**

Чингис хот

2025 он


Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг:khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827 Цахим хаяг:khulankhatanb@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.17 № 72

танай ______________ -ны № ________________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Н.ОДГАРАВ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Дадал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хэнтий аймгийн Дадал сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

- ✓ Тайлант онд 33,749.4 мянган төгрөгийн цалинг НДШ-ийн тайланд дутуу тайлагнасан.
- ✓ Хүнсний материал худалдан авахад 78,572.0 мянган төгрөгийн цахим тендерийг зарлаагүй.
- ✓ Нягтлан бодогчийн ажил хавсран гүйцэтгэсний цалинг анхан шатны баримтгүйгээр 735.5 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.
- ✓ Түүвэр тооллого хийхэд 1,562.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,896.0 мянган төгрөгийн бараа материал дутагдсан зэрэг нийт 116,514.9 мянган төгрөгийн зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай,

Төрийн хэмнэлтийн тухай хууль болон санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

23250207

Тус байгууллага нь тайлант онд улс, орон нутгийн төсвөөс 1,022,768.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны 1,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,018,518.4 мянган төгрөгийг зарцуулан, 3,011.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, харилцах дансанд 200,455.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 117,090.4 мянган төгрөгийн 6 зөрчил алдаа зөрчил илэрч 575.5 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 4,193.5 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 112,321.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 47 арга хэмжээ төлөвлөснөөс, хэрэгжилт 96.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **144,568,437.55** | **265,892,606.88** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 75,099,545.57 | 200,455,223.11 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 75,099,545.57 | 200,455,223.11 |
| **3121** | **Төгрөг** | 75,099,545.57 | 200,455,223.11 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 75,099,545.57 | 200,455,223.11 |
| **33** | **АВЛАГА** | - | 575,559.73 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 575,559.73 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 69,468,891.98 | 64,861,824.04 |
| **351** | **Түүхий эд материал** | 31,000.00 | - |
| 35130 | Эм боох материал | 31,000.00 | - |
| **354** | **Хангамжийн материал** | 69,437,891.98 | 64,861,824.04 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 319,100.00 | 419,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 52,011,697.98 | 63,482,240.34 |
| 35460 | Хүнсний материал | 17,107,094.00 | 959,883.70 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **421,447,911.31** | **393,642,647.67** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 421,447,911.31 | 393,642,647.67 |
| **392** | **Биет хөрөнгө** | 412,441,911.31 | 384,636,647.67 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 369,985,400.00 | 369,985,400.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (55,484,354.00) | (64,621,224.80) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 108,090,751.42 | 107,528,751.42 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (45,128,305.25) | (57,373,965.05) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 65,180,695.76 | 65,180,695.76 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (35,907,542.28) | (41,768,275.32) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 21,969,705.66 | 21,969,705.66 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (16,264,440.00) | (16,264,440.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 9,006,000.00 | 9,006,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,006,000.00 | 9,006,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **566,016,348.86** | **659,535,254.55** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **566,016,348.86** | **659,535,254.55** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 566,016,348.86 | 659,535,254.55 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 582,277,230.28 | 582,277,230.28 |
| 51101 | Өмч: - төрийн | 582,277,230.28 | 582,277,230.28 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (18,859,839.45) | 74,659,066.24 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (18,859,839.45) | (18,859,839.45) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 93,518,905.69 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,598,958.03 | 2,598,958.03 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **566,016,348.86** | **659,535,254.55** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)** | **760,877,200.00** | **1,150,259,600.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | - | **4,374,400.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | - | 4,374,400.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 1,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,000,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ | | 2,374,400.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ | | 1,000,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **760,877,200.00** | **1,145,885,200.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 654,645,200.00 | 1,019,757,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 654,645,200.00 | 1,019,757,200.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 106,232,000.00 | 126,128,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 106,232,000.00 | 126,128,000.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **694,194,240.81** | **1,056,289,450.15** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **694,194,240.81** | **1,056,289,450.15** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 694,194,240.81 | 1,053,278,363.03 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 424,038,953.36 | 697,662,513.00 |
| 210101 | Үндсэн цалин | 276,148,841.46 | 485,177,331.00 |
| 210102 | Нэмэгдэл | 141,645,598.90 | 210,890,402.00 |
| 210104 | Урамшуулал | 6,244,513.00 | 1,594,780.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,337,862.83 | 86,594,839.33 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,831,078.72 | 58,747,858.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,393,660.82 | 6,956,945.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,497,268.42 | 3,475,174.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 871,127.12 | 3,469,604.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,744,727.75 | 13,945,257.18 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 84,797,700.00 | 121,125,362.88 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 54,326,615.00 | 16,296,318.04 |
| 210302 | Түлш, халаалт | 30,471,085.00 | 95,742,688.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 9,086,356.04 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 1,770,840.00 | 589,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,068,600.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 702,240.00 | 274,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 315,000.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 67,160,556.00 | 82,896,123.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 85,300.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 67,075,256.00 | 82,896,123.20 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,846,800.00 | 2,991,550.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,846,800.00 | 2,991,550.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 817,000.00 | 2,836,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 817,000.00 | 2,836,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 40,424,528.62 | 58,582,874.62 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,163,952.00 | 27,569,855.14 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,921,400.00 | 2,659,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 23,339,176.62 | 28,354,019.48 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 3,011,087.12 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 3,011,087.12 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,011,087.12 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **66,682,959.19** | **93,970,149.85** |
| 225 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 451,244.16 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 451,244.16 |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (451,244.16) |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | 66,682,959.19 | 93,518,905.69 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **760,877,200.00** | **1,146,885,200.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | - | **1,000,000.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | - | 1,000,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 1,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,000,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **760,877,200.00** | **1,145,885,200.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 654,645,200.00 | 1,019,757,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 654,645,200.00 | 1,019,757,200.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 106,232,000.00 | 126,128,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 106,232,000.00 | 126,128,000.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **692,152,158.19** | **1,021,529,522.46** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **692,152,158.19** | **1,021,529,522.46** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **692,152,158.19** | **1,018,518,435.34** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 423,630,771.18 | 697,662,513.00 |
| 210101 | Үндсэн цалин | 275,740,659.28 | 483,992,976.00 |
| 210102 | Нэмэгдэл | 141,645,598.90 | 212,074,757.00 |
| 210104 | Урамшуулал | 6,244,513.00 | 1,594,780.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,746,045.01 | 87,170,399.06 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,239,260.90 | 59,323,417.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,393,660.82 | 6,956,945.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,497,268.42 | 3,475,174.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 871,127.12 | 3,469,604.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,744,727.75 | 13,945,257.18 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 84,385,200.00 | 121,125,362.88 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 55,353,500.00 | 15,074,207.71 |
| 210302 | Түлш, халаалт | 29,031,700.00 | 95,742,688.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 10,308,466.37 |
| 2105 | **Нормативт зардал** | 82,919,350.00 | 67,556,712.90 |
| 210502 | Хоол, хүнс | 82,919,350.00 | 67,556,712.90 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,846,800.00 | 2,991,550.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,846,800.00 | 2,991,550.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,357,000.00 | 3,151,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,357,000.00 | 3,151,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,266,992.00 | 38,860,897.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,195,592.00 | 29,744,897.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,071,400.00 | 9,116,000.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | **3,011,087.12** |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 3,011,087.12 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,011,087.12 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **68,725,041.81** | **125,355,677.54** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 68,725,041.81 | 125,355,677.54 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 75,099,545.57 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 75,099,545.57 | 200,455,223.11 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 582,277,230.28 | 2,598,958.03 | (129,611,544.64) | | 455,264,643.67 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **582,277,230.28** | **2,598,958.03** | **(129,611,544.64)** | - | **455,264,643.67** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 110,751,705.19 | | 110,751,705.19 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **582,277,230.28** | **2,598,958.03** | **(18,859,839.45)** | - | **566,016,348.86** |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **582,277,230.28** | **2,598,958.03** | **(18,859,839.45)** | - | **566,016,348.86** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **582,277,230.28** | **2,598,958.03** | **(18,859,839.45)** | - | **566,016,348.86** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 93,518,905.69 | | 93,518,905.69 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **582,277,230.28** | **2,598,958.03** | **74,659,066.24** | - | **659,535,254.55** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,221,984,300.00** | **1,018,518,435.34** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,221,984,300.00** | **1,018,518,435.34** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,221,984,300.00** | **1,018,518,435.34** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **870,753,300.00** | **697,662,513.00** |
| 210101 | Үндсэн цалин | 606,737,700.00 | 483,992,976.00 |
| 210102 | Нэмэгдэл | 261,252,000.00 | 212,074,757.00 |
| 210104 | Урамшуулал | 2,763,600.00 | 1,594,780.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **100,332,000.00** | **87,170,399.06** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 68,227,900.00 | 59,323,417.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,024,400.00 | 6,956,945.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,013,200.00 | 3,475,174.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,013,200.00 | 3,469,604.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,053,300.00 | 13,945,257.18 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **124,128,000.00** | **121,125,362.88** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,272,900.00 | 15,074,207.71 |
| 210302 | Түлш, халаалт | 95,742,600.00 | 95,742,688.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,112,500.00 | 10,308,466.37 |
| 2105 | **Нормативт зардал** | **78,572,000.00** | **67,556,712.90** |
| 210502 | Хоол, хүнс | 78,572,000.00 | 67,556,712.90 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,000,000.00** | **2,991,550.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 2,991,550.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,151,200.00** | **3,151,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,151,200.00 | 3,151,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **42,047,800.00** | **38,860,897.50** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,931,200.00 | 29,744,897.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,116,600.00 | 9,116,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,221,984,300.00** | **1,143,874,112.88** |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,019,757,200.00** | **1,019,757,200.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,019,757,200.00 | 1,019,757,200.00 |
| 1320 | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **126,128,000.00** | **123,116,912.88** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 126,128,000.00 | 123,116,912.88 |
| 120004 | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **76,099,100.00** | **1,000,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 75,099,100.00 | - |
| 4 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **75,099,545.57** |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **200,455,223.11** |

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар 575.6 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруууллаа. Үүнд:

1. Санхүүгийн тайланд НДШ-ийн 575.6 мянган төгрөгийн авлагыг тайлагнаагүй.

Аудитаар нийт 116,514.9 мянган төгрөгийн 5 зөрчил[1] илэрснээс, 4,193.5 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 112,321.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

**5.1 Төлбөрийн акт**

1. Ажил хавсран гүйцэтгэсний цалинг анхан шатны баримтгүйгээр 735.5 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.

2. Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг түүвэрлэн тооллого хийж баталгаажуулахад 1,562.0 мянган төгрөгийн дизель мотор дутагдсан.

3. Бараа материалыг үлдэгдлийг түүвэрлэн тооллого хийж баталгаажуулахад 1,896.0 мянган төгрөгийн мах дутагдсан.

**5.2 Албан шаардлага**

1. НДШ-ийн тайланд 33,749.4 сая төгрөгийн цалинг дутуу тайлагнаж, тусгахгүй орхигдуулсан.

**5.3 Зөвлөмж**

Байхгүй.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийл-сэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаа-гүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| НДШ-ийн авлага тайлагнаагүй | 1 | 575.6 | 1 | 575.6 | | | 1 | 575.6 | | | | |
| **Дүн** | 1 | 575.6 | 1 | 575.6 | | | 1 | 575.6 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалт-ны тоо | Тоо | Дүн |
| Илүү цалин олгосон | 1 | 735.5 | 1 | 735.5 | | | | | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгө дутагдсан | 1 | 1,562.0 | 1 | 1,562.0 | | | | | | | | |
| Бараа материал дутагдсан | 1 | 1,896.0 | 1 | 1,896.0 | | | | | | | | |
| Цалинг НДШ-ийн тайланд дутуу тайлагнасан | 1 | 33,749.4 | | | 1 | 33,749.4 | | | | | | |
| **Дүн** | 1 | 37,942.9 | 3 | 4,193.5 | 1 | 33,749.4 | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хүүхдийн хоолны цахим тендер зарлаагүй | 1 | 78,572.0 | | | 1 | 78,572.0 | | |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 78,572.0 | | | 1 | 78,572.0 | | |
| **Нийт дүн** | 1 | 78,572.0 | | | 1 | 78,572.0 | | |

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаар-лалттай | Сөрөг | Дүгнэлт гаргахаас татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **0** | **1** | | |

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 06 өдөр Дугаар 04-ХЭА-2025/055/НА-СТА-ТШ3 Чингис хот
A2370452

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд 9 дүгээр сард ажил хавсран гүйцэтгэсний цалинг анхан шатны баримтгүйгээр 735.5 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох “ журмын 4.2.3.3-д “*Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү тооцож олгосон 735.5 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Н.Одгарав, нягтлан бодогч Э.Мөнхмаа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.ХУЛАНХАТАН

23255000 4

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 06 өдөр Дугаар 05-ХЭА-2025/055/НА-СТА-ТШЗ Чингис хот
А2370452

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант оны үндсэн хөрөнгийн үлдэгдлийг түүвэрлэн тооллого хийж баталгаажуулахад 1,562.0 мянган төгрөгийн дизель мотор дутагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д ”Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *“Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох “ журмын 4.2.3.7 -д *“Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан”* гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дутагдсан хөрөнгийн үнэ 1,562.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Н.Одгарав, нягтлан бодогч Э.Мөнхмаа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.ХУЛАНХАТАН

23255000б

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 06 өдөр Дугаар 06-ХЭА-2025/055/НА-СТА-ТШ3 Чингис хот
А2370452

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант оны бараа материалыг үлдэгдлийг түүвэрлэн тооллого хийж баталгаажуулахад 1,896.0 мянган төгрөгийн мах дутагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д ”Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *“Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох “ журмын 4.2.3.7 -д *“Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан”* гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дутагдсан махны үнэ 1,896.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Н.Одгарав, нягтлан бодогч Э.Мөнхмаа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.ХУЛАНХАТАН

232550006

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 дугаар сарын 05 Дугаар 02-ХЭА-2025/055/НА-СТА-ТШ3 Чингис хот

А 2370452

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүүхдийн хоолны 78,572.0 мянган төгрөгийн материал худалдан авахад цахим тендер зарлаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д "*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана*". гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг эрхлэгч Н.Одгарав, нягтлан бодогч Э.Мөнхмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.ХУЛАНХАТАН

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

# ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 06 Дугаар 04-ХЭА-2025/055/НА-СТА-ТШЗ Чингис хот

А2370452

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын хүүхдийн Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 8 дугаар сард 29 ажилтны 33,749.4 мянган төгрөгийн цалинг НДШ-ийн тайланд дутуу тусгаж, тайлагнаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д *"хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг эрхлэгч Н.Одгарав, нягтлан бодогч Э.Мөнхмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.ХУЛАНХАТАН

2317144297
СЮА0046 9074082

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

232540004